

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ТӨСӨЛ БОЛОН БУСАД ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЧОО

Д.Д	Байгууллага	Ирүүлсэн санал	Тайлбар
1	Мэргэжлийн согог зүйч багш нарын төлөөлөл 2020.01.04-ны № 21-1	<p>”Тусгай сургууль” гэсэн булгийг шинэ хуулийн төсөлдөө тусгах;</p> <p>Улсын хэмжээнд ажиллаж байгаа 6 тусгай сургууль 2 цэцэрлэгийг төрийн захиргааны төв байгууллага Боловсрол шинжлэх ухааны яамны мэдэлдээ үлдээгээсэй гэж ахмад согог зүйч багш бид нар хүсэж байна;</p>	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлд тусгасан.
2	Ёс зүй сэтгэл судлалын боловсролын төв НҮТББ 2020.12.25 №05	<p>Сургуулийн өмнөх, бага боловсрол эзэмшихэд нь хүүхдийг хүмүүжил, төлөвшилтэй болгох гэснийг ”хүмүүжүүлэх, төлөвшүүлэх” гэх. Энд мөн хүнийг сургуулийн өмнөх, бага боловсрол эзэмших үед нь хүмүүжүүлж, төлөвшүүлэх юм шиг бичиж. Хүн насан туршдаа, бүх шатны боловсрол эзэмшихдээ сурч, хөгжиж, хүмүүжиж, соёлжих замаар төлөвшдөг;</p> <p>4.1.4.-т юуг ”боловсролын түвшин” гэж үзэх тухай хэсэгт чадварыг гэсэн угийн ард дадлыг гэж нэмэх. Дадал зуршил болгож, тогтоон хэвшүүлж байж мэдлэгийг чадвар болгоно, Дадал болгоогүй чадвар гэгч хуний жинхэнэ эзэмшсэн чадвар биш. Анхдагч, чадварыг тууштай хичээн Дадуулснаар сая эзэмшсэн чадвар болгоно;</p> <p>5.1.-д ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж гэснийг “ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг сахидаг” гэх;</p> <p>15.9.2-т багшийн ёс зүй гэснийг ”багшийн ёс суртахуун” болгох. Ингэж өөрчлөхийг хичээнгүйлэн хүсэж байна!!! Ёс зүй гэдэг нь философийн шинжлэх ухаанаас</p>	<p>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн 3.2 -т тусгасан.</p> <p>Боловсролын түвшин нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон дээд гэсэн ангилал тул дадал гэснийг нэмэх боломжгүй юм.</p> <p>Боловсролын ерөнхий хуулийн төслийн 4.1-д “... ёс зүйг дээдлэн сахисан” гэж тусгасан.</p> <p>Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлэн ёс зүй гэсэн нэр томъёог хэрэглэсэн</p>

		салбарласан шинжлэх ухааны нэр, ёс суртахуун нь хунд тавигддаг шаардлагууд, хүний тухайд ёс суртахуун гэдэг үгийг л хэрэглэх учиртай. Мэргэжилтнүүдийн хувьд багшийн ёс суртахуун, удирдах ажилтны ёс суртахуун, нийгмийн ажилтны ёс суртахуун гэх, иргэдийн хувьд эцэг эхийн ёс суртахуун, хүүхдийн ёс суртахуун, суралцагчийн ёс суртахуун гэх,	байдаг тул бусад хууль тогтоомжтой уялдуулж ёс зүй гэснийг хэрэглэсэн.
		17.9.-д агуулга, хөтөлбөр, арга зүйл дараах асуудлыг заавал тусгаж гэсэн хэсэгт „арга зүйд, зүйлийг” гэх. Нэг асуултад хариулагдаж, нэгэн утга илэрхийлж, хамт хэлэгдэн нэршиж хэвшсэн нэр томьёо, утга бүтцийн нэгдэлтэй нийлмэл үгсийг хамт бичнэ гэсэн дүрмийн дагуу арга зүй, ёс зүй, хууль зүй ... гэх	Хуулийн төсөлд өөрчлөлт оруулсан.
		17.9.2.-хувь хүн, гэр бүлийн зөв хөгжил төлөвшилтөд дутаж байгаа зүйл ёс суртахууны тухай мэдлэг, боловсрол, хүмүүжил тул ”хувь хун, гэр бүлийн зөв хөгжил төлөвшилт” гэх, энэ хэсэгт ёс суртахууны хүмүүжил, боловсрол гэж нэмэх;	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлэн ёс зүй гэсэн нэр томьёог хэрэглэсэн байдаг тул бусад хууль тогтоомжтой уялдуулж ёс зүй гэснийг хэрэглэсэн.
3	Монголын хувийн хэвшлийн бага дунд Сургуулиудын холбоо ТББ 2020.01.12 №14	Шинэчлэн найруулсан хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтад ”Хуульд өөрөөр заагаагүй бол ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ нь нэг сард ногдох хөдөлмөрийн хэлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна” гэж тогтоогоод уг заалтад заасан ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх ажлын байрыг мөн хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.2, 22-р зүйлийн 22.1 дэх хэсгийн 3, 23 дугаар зүйлийн 23.4, 34 дүгээр зүйлийн 34.3-т тус тус тусгажээ. Гэвч эдгээр хөнгөлөлт, чөлөөлөлтөд бух шатны боловсрол, шинжлэх ухааны байгууллагад ажиллах нарийн мэргэшсэн гадаад багш, ажилтныг хамруулалгүй үлдээжээ. Хуулийн төслийн дээрх заалтууд нь эдүгээ мөрдөгдөж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар	Энэ харилцаа нь Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамаарах тул Боловсролын ерөнхий хуулийн төсөлд тусгах шаардлагагүй юм.

		<p>зүйлийн 12.1.3 дахь заалтад "дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хуч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсэн горимоор олгох"-оор заасныг; Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад "өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана" гэснийг тус тус зөрчиж байна.</p> <p>Иймд, Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх тухай" журмын 3. 1 .3-д "боловсролын байгууллага, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх, мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтан"-ыг ажлын байрны төлбөрөөс чөлөөлж ирсэн заалтыг баримтлан, шинэчлэн найруулсан хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.3-т "22.1 дэх хэсгийн 4" гэсэн заалтыг нэмж, "Монгол Улсад ажиллах энэ хуулийн 22.1 дэх хэсгийн 3, 4- т заасан ангиллын ажлын байранд ажиллах гадаад ажилтан, энэ хуулийн 23.4-т заасан гамшгийн хор уршгийг арилгах гадаад ажилтан авч ажиллуулах ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө" гэж тусгаж өгөхийг хүсэж байна;</p>	
4	<p>Монголын төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн холбооны нэгдсэн зөвлөл</p> <p>2020.12.30 №А12/30</p>	<p>Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-д "хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багц хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд хууль тус бүрийн үзэл баримтлалыг тодорхойлно" гэж заасан. Боловсролын эдгээр багц хуулийн:н төслүүд маань тус тусдаа үзэл</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан.</p>

		<p>баримтлалтай байх юм байна, Гэтэл Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн үзэл баримтлал нь батлагдаагүй байхад ил тод болоогүй байхад хуулийн төслийн бичвэрийг бичиж, санал авах ажиллагаа явуулж байгаа нь хуульд нийцэхгүй байна. Боловсролын салбарын оролцогчид бид уг хуулийн төслийн үзэл баримтлал дээр салбарын байр суурь, бодлого, зарчмаа тодорхой болгож уг үзэл баримтлалд тусгах арга хэмжээг авах хүсэлтэй байна. Үзэл баримтлал тодорхойгүй, батлагдаагүй байхад хуулийн төслийг боловсруулах ажлыг явуулж байгаад бид шүүмжлэлтэй хандаж байна;</p>	
		<p>Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар¹ хучин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудыг 5 жилд тутамд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийдэг. Энэ үнэлгээ, судалгаагаар эдгээр хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, хууль зорилгодоо хүрсэн эсэх, хэрэгжилтийн түвшин ямар байгаа зэргийг судалгаагаар тогтоодог. Одоо үйлчилж байгаа Сургуулийн өмнөх боловсролын хуульд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй байгаа нь хууль боловсруулах ажил судалгаа шинжилгээ нь дээр үндэслэх зарчмыг зөрчиж байгаа болно;</p>	<p>Тус хуулийн төслийг боловсруулахаас өмнө одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөө, тандан судалгаа зэрэг бүхий л судалгааг 2017 оноос эхлүүлсэн бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг ханган хуулийн төслийг боловсруулсан. Энэ хүрээнд Боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх судалгаа, Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа /Боловсролын тухай хуулийн/-г тус тус хийсэн болно.</p>
		<p>3.Хуулийн үзэл баримтлалын хүрээнд боловсролын салбарын байгууллагын хувийн хэвшлийн цэцэрлэгт өмчийн хэлбэр үл харгалзан, түүний багш, ажилтан, суралцагч, эцэг, эхчүүдэд адил тэгш хандах зарчмыг тууштай баримтлах, цэцэрлэгийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг</p>	<p>Хуулийн төсөлд зааснаар төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгт санхүүжилтийг олгоно. Нийгмийн баталгаа нь төрийн болон орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэгийн багш ажилтан нарыг тогтвортой</p>

		<p>дэмжих бодлого баримтлах, хувийн цэцэрлэгүүдийн багш, ажилтнуудыг нийгмийн баталгааг хангахад онцгой анхаарахад чиглэсэн баталгааг хуулийн төсөлд тусгах саналтай байгаа юм. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага бол нийтийн эрх ашигт үйлчилж, төрийн гүйцэтгэх ёстой чиг үүргийг хариуцан гүйцэтгэн, нийгмийн үйлчилгээ үзүүлж буй ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн этгээд юм. Иймд эрх зүйн байдал, хэлбэрийг дордуулахгүй байх зарчмыг тууштай баримтлах нь зүйтэй болно;</p>	<p>ажиллуулах зорилгоор хуульд тусгасан. Ингэснээр сургалтын чанар сайжрах, төрийн болон орон нутгийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмж сайжрах зэрэг эерэг нөлөөтэй юм.</p>
		<p>Боловсролын ерөнхий хуулийн төсөл, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулийн төсөл нь төрийн бус өмчийн 422 цэцэрлэг, 5200 гаруй багш ажилтнуудаас гарсан саналыг нэгтгэн үзэхэд ут хуулийн үндсэн зарим нэг агуулгад хүүхдийн сурах эрх чөлөөг боомилсон, эмзэг булгийн хүүхдийн эрүүл аюулгүй байдалд сөрөг нөлөөлөхүйц хүн бүрийн тэгш боловсрол хүртэх эрхийг ноцтой зөрчсөн, боловсролын байгууллагад ажиллаж байгаа багш нарыг ялгаварлан гадуурхах замаар боловсролын тогтолцооны тогтвортой байдалд заналхийлсэн сөрөг ур дагавартай үзэл санаа хөндөгдөж байна гэж үзэж байгаа учраас дараах асуудлыг нягтлан судалж, улс эх орныхоо үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон Боловсролын тогтолцоог бүхэлд нь өөрчилж буй энэхүү асуудалд нухацтай хандахад анхаарлаа хандуулж, бидний саналыг хуульд тусгахад дэмжин ажиллана үү. Дээрх асуудлыг дараах байдлаар тайлбарлаж байна.</p> <p>Хоёр настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулах замаар цэцэрлэгийн хүүхдийн тоог цөөлөх бодлогыг шүүд хуульчилж байна. Энэ нь дараах сөрөг дагаврыг нийгэмд бий болгохоор байна. Тухайлбал Өнөөгийн хуулиар хүүхэд харах үйлчилгээ нь төлбөртэй. Гэтэл эмзэг булгийн буюу хамгийн анхаарах</p>	<p>ЮНЕСКО-гийн Статистикийн Хүрээлэнгийн 2020 оны албан ёсны мэдээллээр нийт 225 улсын 2.7 хувь нь буюу 6 улс хүүхдийг 2 настай, 69.3 хувь нь 3 настай, 21.3 хувь нь 4 настай, 6.2 хувь нь 5 настай, 0.4 хувь нь 6 настайд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ буюу цэцэрлэгт элсүүлж байна.</p> <p>Дээрх судалгаанаас харахад дэлхийн ихэнх улс оронд хүүхдийг 3 наснаас нь эхлэн сургуулийн өмнөх боловсролд элсүүлэх хандлага давамгайлж байгаа тул сургуульд элсэх насыг олон улсын жишигт нийцүүлэхээр хуулийн төсөлд тусгаад байна.</p> <p>Дэлхийн улс орнуудад 0-2 настай хүүхдэд боловсрол эзэмшүүлэх гэхээс илүү гэр бүл, эцэг эхийн асрамж, хамгаалал, хоол тэжээл,</p>

		<p>ёстой нийгмийн нэгэн давхаргын хоёр настнууд гэртээ байх шаардлагатай болох нь. Өнөөдөр гэртээ цоожлогдож түлэгдсэн, бэртсэн, гэмтсэн хүүхдүүд олонх нь аюулыг урьдчилан харж мэдэхгүй хоёр настнууд байдгийг энд дурдан сануулах хэрэгтэй байна</p> <p>Хүүхэд харах үйлчилгээ нь боловсролын байгууллага биш, тэнд ажиллах хүмүүс нь цөөн өдрийн сургалтад хамрагдсан багш мэргэжилгүй (18 нас хүрсэн л бол эрх авах боломжтой) байхаар заасан байдаг. Энэ нь хоёр настай хүүхдийн боловсролыг үгүйсгэсэн буюу сурч боловсрох эрхийг нь боомилж байгаа ноцтой асуудал юм. Хоёр настнууд бие даах, нийгэмших, хэлд орж, ярих чадвартай болж, хөгжлийн суурь тавигддаг чухал үедээ хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх багшгүй нөхцөл рүү шахагдаж байна</p> <p>Энэхүү хууль нь нэг талаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахыг дэмжиж байгаа харагдах хэдий ч нэг хүүхдэд оногдох хувьсах зардлыг төрийн цэцэрлэгт олгохоор тусгаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжиж, үнэхээр тэгш хамрагдалтыг хэрэгжүүлэе гэж байгаа, хөгжлийн ялгаатай хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж байгаа байгууллага, багш бүхэн бол өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хүртэх ёстой. Тэгж байж тусгай боловсрол шаардлагатай хүүхдийн боловсролын түвшин дээшлээд зогсохгүй, улсаас халамж нэхэх хуний тоо ирээдүйд огцом буурах боломж бүрддэг гэдгийг олон улсын жишээ харуулдаг;</p> <p>Боловсролыг түгээгч, эх орныхоо хойчийг бэлтгэгч багш нар маань өнөөдөр хаана ажилладагаараа ялгаварлан, гадуурхагдах ёсгүй. Багш нар бол боловсролыг тогтвортой авч явах гол түүчээлэгч нар. Гэтэл энэхүү хуульд хувийн хэвшлийн цэцэрлэгт ажилладаг багш тэтгэвэрт гарах үеийн нэг удаагийн</p>	<p>аюулгүй орчинд эрүүл хүн болгож өсгөхөд бодлогоо чиглүүлж байна.</p> <p>Иймд тус хуулийн төслийн 10.5 дахь хэсэгт “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсрол, нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. <i>Тайлбар: Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр гэж 0-2 настай хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хэл яриа, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих баримт бичгийг ойлгоно.</i>” гэж заасан тул 1-2 насны хүүхдийн боловсролын асуудлыг орхигдуулаагүй зохицуулсан гэж үзэх боломжтой байна.</p>
--	--	--	---

		тусламж, бусад тэтгэмж, урамшууллыг хүртэх эрхгүй хун болж байгаа. Гэтэл хуулийн маань үзэл баримтлалд боловсролыг тэгш хүртээмжтэй олгоно гэж сайхан үгээр тодорхойлсон байгаа. Хувийн хэвшлийн Сургууль цэцэрлэгийн боловсон хүчний буюу цаашлаад багшийг тогтвортой ажиллах боломжгүй болгож байгаа нь бодит үнэн билээ.	
		18.2.Боловсролын сургалтын байгууллага нь өмчийн хувьд ашгийн болон ашгийн бус хэлбэртэй байж болно;	Хуулийн төсөлд туссан байгаа
5	Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн хороо 2020.12.30 №121	11.1-д Эчнээ хэлбэрийг оруулж болох үү. Эсвэл цаашид ЭЧНЭЭ гэж байхгүй байх юм үү.;	Сургалтын хэлбэрийг Боловсролын ерөнхий хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан бөгөөд ингэхдээ эчнээ хэлбэрийг хуулийн төслөөс хассан болно.
		16.5-д "төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны ажилтан" гэж нэмж оруулах. Нийтлэг үйлчилгээний ажилчдыг ямар учраас оруулаагүй нь тодорхой бус байна;	Саналыг хүлээн авч Боловсролын ерөнхий хуулийн төслийн 13.3.5-д тусгасан.
		16.6 -д "Төрийн албаны тухай хуулийн 60.1 дагуу" гэж тодорхой оруулах	Ерөнхий утгаараа туссан.
		16.6- д буцалтгүй тусламжийн эх үүсвэрийг зааж өгөхгүй бол хаанаас санхүүжих нь тодорхойгүй байна;	Уг харилцааг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу зохицуулах тул заавал хуульчлах шаардлагагүй гэж үзлээ.
		23.4-д "Төрийн өмчид мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллага байгуулах асуудлыг засгийн газар, татан буулгах, өөрчлөх асуудлыг тухайн хамт олон, суралцагчдын төлөөллийн байгууллага болох УЗ, Эрдмийн зөвлөл, ҮЭ, Оюутны зөвлөлийн саналыг харгалзан ЗГ шийдвэрлэнэ" гэж оруулах;	Боловсролын ерөнхий хуулийн төслийн 28 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 28.1.7 дахь заалтад тусгасан.

		29.1-д мөн "татан буулгах, өөрчлөх асуудлыг тухайн хамт олон, суралцагчдын төлөөллийн байгууллага болох ҮЗ, Эрдмийн зөвлөл, ҮЭ, Оюутны зөвлөлийн саналыг харгалзан ЗГ-ын шийдвэрээр" гэж оруулах;	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийцүүлэн тусгасан.
		31.3-д "уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" гэсэн томъёоллыг өөрчлөх, эсвэл тодорхой болгох;	Саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан
		32.1-д Боловсролын үндэсний газар" бүх их дээд сургуулийн дипломыг хэвлүүлэх, түгээх, олгох ажлыг хариуцаж болохгүй. Их дээд сургуулиуд мэргэжлийн дипломоо өөрсдөө олгодог байх нь зөв. Учир нь бүх их дээд сургуулиудын дипломыг нэг газар шийдэж өгөх нь хяналтгүй болж хуурамч диплом гарах магадлал ихэснэ;	Боловсролын ерөнхий хуулийн төсөлд заасан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй байхаар хуулийн төсөлд тусгасан.
		36.1 .3-д " 15.11.1. 15.11.2.,-ыг тус тус үндэслэн" гэж тодруулах	Холбогдох заалтыг өөрчлөн найруулсан
		40.1-ийн найруулга томъёоллыг тодорхой болгох;	Саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан
		44.2.1-д "Төрийн өмчийн" гэж тодотгож өгөх. Учир нь өндөр төлбөртэй хувийн сургуулиуд хувьсах зардал авч байгаа нь цаанаа бизнес, эрх ашиг явж байна;	Хуулийн төслийн холбогдох заалтыг өөрчилсөн.
		45.1-ээс "хувьсах зардлыг төсвөөс санхүүжүүлэх" гэснийг хасах. 44.2.1-тэй ижил үндэслэлээр хасах;	Хуулийн төслийн холбогдох заалтыг өөрчилсөн.
		Дээд боловсролын тухай хууль	
6	Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо 2020.12.01 №89	8.1-д "коллежид" гэж найруулга засах;	Саналыг хүлээн авч өөрчилсөн.
		10.1-д "Дотоод журамд заасны дагуу" гэдгийг хасаж "Зөвхөн холбогдох хууль тогтоомжийг үндэслэн 36 сарын тэтгэмжийг төрөөс нэг удаа олгоно" гэж бичих. Шаардлагатай бол Боловсролыг ерөнхий хууль, Төрийн албаны тухай хуулийн заалтуудыг зааж болно;	Төрийн албаны тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжийн тухай заалт нь зөвхөн Засгийн газраас баталсан төрийн албанд хамаарах албан тушаалын ангилалд заасан төрийн албан

			хаагчид хамааралтай тул саналыг хүлээн аваагүй
		Боловсролын ерөнхий хуульд	
		Хотын анги дүүргэлт хэтэрсэн ачаалал ихтэй сургуульд ажилладаг багш нарт хүүхдийн тоонд харгалзуулсан нэмэгдэл олгох;	Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад заасан эрүүл мэнд, хөдөлмөр, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батлах боловсролын болон багш, ажилтны ажлын норм нормативаар зохицуулна
		Багш нарын тэтгэврийн насыг эрэгтэй 55, эмэгтэй 50 болгох;	Энэхүү харилцааг энэ хуулиар зохицуулахгүй тул саналыг хүлээн аваагүй
		Багш нарыг урьдчилгаа төлбөргүй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцжуулах төсөлд хамруулах;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэж тусгасан
		5. Багш бүрийн эрүүл мэндийн асуудлыг анхаарч, жилд 1-2 удаа үнэ төлбөргүй үзлэг шинжилгээнд хамруулах, багш нарын сувилалтай байх;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дах заалтад багш, ажилтны эрхэд болон 35 дугаар зүйлийн 35.1.7 дах заалтад “боловсролын сургалтын байгууллагын нийт албан хаагчийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг авах”-ыг аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэгт тусгасан
		Цалин 1сая 500000 дээш ажилласан жилээр нь 5-аас дээш жилд 1сая 5-10 жилд 1 сая 500000, 10-аас дээш	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3.1. дах заалтад “багш нь ажлын гүйцэтгэл, ур чадвар, бүтээлч

		жил ажилласан 2 саяас дээш/ 1 цагийн хөлсний үнэлэмжийг нэмэгдүүлэх;	байдал, суралцагчийн ахиц дэвшлийн үнэлгээнд үндэслэсэн цалин хөлсөөр хангагдах” гэж тусгасан
		Түрээсийн орон сууцаар хангаж, тэтгэвэрт гарахад нь.хувийн өмч болгон олгох;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэж тусгасан
		Ажлын байранд өөрийгөө хөгжүүлж, хичээл, сургалтын ажлын чанарыг сайжруулах чиглэлээр судалгаа хийхэд шаардлагатай тусгай өрөө танхим, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дах хэсэгт “13.5.Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийг сургалтын үйл ажиллагаанд шаардагдах техник тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангана” гэж тусгасан
		Судалгаа хийх боломж, орчноор хангах, илүү цагаар сууж хийсэн судалгааг нэмэлт ажил үүрэгт тооцон цалин хөлс олгох;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3.1. дах заалтад “багш нь ажлын гүйцэтгэл, ур чадвар, бүтээлч байдал, суралцагчийн ахиц дэвшлийн үнэлгээнд үндэслэсэн цалин хөлсөөр хангагдах” гэж тусгасан
		Дугуйлан секц хичээллүүлсний нэмэгдэл хөлс олгодог болох	Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.7 дах хэсэгт “...болон төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх дугуйлангийн зардлын тодорхой хувийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж тусгасан

	<p>Анги удирдсан багш нарт ангитайгаа ажиллах хүмүүжлийн 2-4 цаг гаргаж өгөх илүү цагт тооцон, илүү цагийн хөлс өгөх;</p>	<p>Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад заасан эрүүл мэнд, хөдөлмөр, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батлах боловсролын болон багш, ажилтны ажлын норм норматив болон 30.1.6 дэх заалтад заасан багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагаар энэхүү харилцааг зохицуулна</p>
	<p>Багшийн нийгмийн баталгаа болсон үндсэн цалинг маш сайн нэмэх хэрэгтэй;</p>	<p>Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3.1. дах заалтад “багш нь ажлын гүйцэтгэл, ур чадвар, бүтээлч байдал, суралцагчийн ахиц дэвшлийн үнэлгээнд үндэслэсэн цалин хөлсөөр хангагдах” гэж тусгасан</p>
	<p>Тэтгэвэрт гарч байгаа багш нарыг сүүлийн 7 жилийн цалингийн дунджаар биш 5 жилийн дунджаар тооцож оруулах;</p>	<p>Энэ хуулиар зохицуулагдахгүй тул саналыг хүлээн аваагүй</p>
	<p>Багш өөрийгөө хөгжүүлэх, хамтран хөгжих боломжийг сургуулиас хангах, зардлыг төр болон сургуулиас даах;</p>	<p>Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дах хэсэгт “Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийг сургалтын үйл ажиллагаанд шаардагдах техник тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн материалаар хангана” гэж тусгасан</p>
	<p>Багшийг ажлаа үр дүнтэй хийх, сурагчдад олгох мэдлэг чадварыг олгох тоног төхөөрөмжөөр хангах /5 жил тутам шинэчилж байх/;</p>	<p>Хуулийн төслийн 35 дугаар зүйлийн “35.1.4.боловсролын байгууллагын хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр</p>

			хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах гэж тусгасан
		Сурах бичгийг дагасан судлагдахуун бүрийн дагалдах хэрэглэгдэхүүнтэй болох;	Хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан сурах бичигт тавигдах стандарт, шаардлагаар зохицуулах тул саналыг хүлээн аваагүй
		Орон нутагт ажилласан хугацааны нэмэгдлийг 3 жил болгох, үүний нийслэл хотод ажиллаж буй багш нарт агаарын бохирдол дүү чимээ, анги дүүргэлт, ачаалал зэргийг харгалзан тухайн нэмэгдлийг олгодог болгох;	Саналыг хүлээн авч хуульд өөрчлөлт оруулсан боловч холбогдох яам дэмжээгүй тул хэвээр үлдээсэн.
		Анги даалтыг хүүхдийн тоотой уялдуулж анги даалтын нэмэгдлийг нэмэгдүүлэх;	Хуулийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад заасан эрүүл мэнд, хөдөлмөр, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тус тус хамтран батлах боловсролын болон багш, ажилтны ажлын норм норматив болон 30.1.9 дэх заалтад заасан багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагаар энэхүү харилцааг зохицуулна
		Боловсролын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд багш ажилтны нийгмийн баталгаа гэсэн нийгмийн хамгааллын зүйл заалтыг тусгах, дэлгэрүүлэх	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 хэсэгт багш, ажилтны нийгмийн баталгаатай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан
		Боловсролын байгууллагын багш ажилтны нийгмийн баталгааг сайжруулах тэгснээр ур дүн гарна;	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 хэсэгт багш, ажилтны нийгмийн баталгаатай холбоотой харилцааг зохицуулсан
		Боловсролын ерөнхий хуулийн төслийн 16 дугаар зүйлийн “Багш ажилтны нийгмийн баталгаа, хамгаалал” гэж зүйлчилж тухайн зүйл заалтууд тус бүрд БШУЯ,	Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 хэсэгт багш, ажилтны нийгмийн баталгаатай холбоотой харилцааг

		<p>Сангийн яам, ХНХЯ болон МБШУ-ны ҮЭ-ийн холбооны төлөөлөл оролцсон хамтарсан хэлэлцүүлэг хийж саналуудыг бодит зүйлсийг тусгах;</p>	<p>зохицуулсан бөгөөд СЯ, ХНХЯ-ын саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан. МБШУ-ны ҮЭ-ийн төлөөлөл хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсэгт ажилласан болно. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэлэлцүүлгийг орон нутгийн багш ажилтны төлөөлөл, аймаг, нийслэлийн Боловсролын газрын төлөөлөл, яамны харьяа байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны төлөөлөл зэрэг бусад төлөөллийг оролцуулж зохион байгуулсан.</p>
--	--	---	---